



Дөнер Кебаб түргэн хоолны салбар нээн ажиллуулах хүсэлт авах анкет

Бид та бүхэнд “Cola Kebab”, “Flame Café and Grill” брэндүүдийн франчайз эрх болон өөрсдийн бренд нэр бүхий Кебаб түргэн хоолны үйлчилгээ үзүүлэх газрыг нээн ажиллуулах боломжуудыг санал болгож байна. Та бидэнтэй хамтран ажиллахыг хүсвэл энэ анкетыг сайтар уншиж зохих судалгаа дүгнэлтийг хийж бөглөн бидэнд илгээнэ үү. Энэ нь таны ирээдүйд амжилттай ажиллах үндэс суурь болох юм. Манай найрсаг хамт олон таньтай 7 хоногийн дотор холбогдох болно.

Гэрээ хийх үе шат:

1. Анкет хүлээн авах (анкетыг манай www.gfc.mn хаягаар орж ‘Франчайзинг эрх’ хэсэгт байрлах асуулгыг бөглөх, эсвэл доорх анкетыг бөглөөд 1000goodfood@gmail.com и мэйл-руу илгээх)
2. Ярилцлага
3. Салбарын байршил, обектыг очиж үзэх
4. Төлбөр төлөх:

Төлбөрт дараах зүйлс багтсан болно.

- Шинэ салбарын дотоод тохижилт зохион байгууллалтын зөвөлгөө
 - Салбарын үйл ажиллагааны гарын авлага
 - 5 хоногийн дадлага сургалт /зөвхөн удирдах албан тушаалтанд/
 - Салбарын видео реклам хийж сошиал медиагаар 1 сар сурталчилах
 - Цахилгаан хутга /1 жилийн баталгаат засвар үйлчилгээтэй/
5. Гэрээ хийх

Анкет асуулга:

1. Овог нэр:

2. Байгууллагын нэр, регистр:

3. Утасны дугаар: И-мэйл хаяг:

4. Та бизнес эрхэлж байсан туршлагатай юу? Тийм бол өөрийн бизнесийн туршлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

6. Таны салбарын өдөр тутмын үйл ажиллагааг ямар хүн хариуцаж явах вэ? Тэр хүний ажлын туршлага, мэдээлэл?

7. Таны салбар нээх байршил хаана вэ? Таны хувийн эзэмшил биш бол сарын түрээсийн зардал хэд вэ?

8. Таны салбар нээх газрын хүн амын төвлөрөл, тэдний амьдралын түвшин, худалдан авах чадварын талаарх мэдээлэл бүхий орчны судалгаа.

9. Таны салбар нээх ажлын байр гаднаа зогсоолтой юу?

10. Байр тань шөнө ажиллах боломжтой эсэх? Тусдаа өөрийн гэсэн хаалгатай юу? Галын дүгнэлт авах болон газ ашиглах боломжтой эсэх? Агааржуулалтын хоолой, хиншүү сорогч суурьлуулах боломжтой эсэх?

11. Орон сууцны доор бол дээд давхрын оршин суугчид дуу чимээ, хиншүү, үнэр

зэргээс хэл ам хийх магадлалтай эсэх?

12. Таны бодлоор танай байрны байршилийн давуу тал болон сул тал?

13. Таамаглаж буй өдрийн орлого? Санхүүгийн үр ашгийн тооцоо?